

# **ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙГМИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА**

**УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, БИЗНЕСИЙН ТӨВ  
ЗОХИСТОЙ ХӨГЖЛИЙН ЖЕНДЭР ТӨВ  
ЗӨВЛӨХ НЭГЖ. ЗБН  
ХАМТРАН ГҮЙЦЭТГЭВ**

Улаанбаатар хот 2000 он

**“Монголын төрийн бус байгууллагуудын нийгмийн салбарт  
хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн судалгаа” сэдэвт  
судалгааны тайлан**

Агуулга	
Удиртгал	3
Нэг. Монгол улсын Засгийн газраас 2000-2004 онд хэрэгжүүлэх нийгмийн бодлогын үндсэн зорилт, тэргүүлэх чиглэлүүд /товч тойм/	4
Хоёр. Монголын төрийн бус байгууллагуудын өнөөгийн байдал	5
1. Эрх зүйн орчны бүрдэлт	
2. ТББ-ын төрөл, хэлбэр	
3. ТББ-ын ангилал /үйл ажиллагааны чиглэлээр/	
4. ТББ-ын орлогын эх үүсвэр, зарцуулалт	
Гурав. ТББ-уудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн төрөл хэлбэр, санхүүжилт	9
Дөрөв. ТББ-уудын үйл ажиллагаа ба Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн уялдаа	11
Тав. ТББ-уудын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх давуу ба сул тал, үр дүн	13
1. Зардал, үр дүн	
2. Зорилтот бүлэгтээ хүрдэг эсэх	
3. ТББ-ын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхи	
4. Дотоод гадаад нөөцийг дайчилсан байдал	
Зургаа. ТББ ба донор байгууллагуудын хамтын ажиллагаа	26
Долоо. Судалгааны дүн, санал зөвлөмж	28
Хавсралтууд:	Монголын төрийн бус байгууллагуудын нийгмийн
	салбарт
	хэрэгжүүлсэн
	төслүүдийн матриц

## **Удиртгал**

Монголын хөгжлийг дэмжигч, хандивлагчдын VII уулзалтын үеэр нийгмийн салбарыг хөгжүүлэхэд төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, энэ үйл ажиллагааны зорилтот түвшинг тодорхойлох үзүүлэлтүүд дээр санал нэгдсэн билээ. Удахгүй болох Парисийн уулзалтаар монголын нийгмийн салбарт үзүүлэх тусламжийн асуудлыг тусгайллан авч үзэхээр шийдвэрлэсэн. Хандивлагчид хөрөнгө оруулах, тусламж үзүүлэхдээ нийгмийн салбар нь харьцангуй олон талт, харилцан уялдаа бүхий салбар болохыг, тэгэхдээ төрийн бус байгууллага (ТББ)-уудын олон нийтэд хүрэх чадавхийг харгалзсан юм. Иймд хоёр болон олон талт хамтын ажиллагааны шугамаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, цаашдын үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Судалгаанд хамрагдах ТББ-ыг сонгохдоо : а/ Хууль зүй, дотоод хэргийн яаманд /odoogийн нэрээр/ бүртгэгдсэн ТББ-ын жагсаалт; б/ Нийгмийн асуудлын чиглэлээр олон нийтэд танил болсон байдал, нэр хүнд; в/ Үйл ажиллагааны идэвх; г/ Салбарын төлөөллийг харгалзан үзэв. Судалгаанд дотоодын 80 ТББ, олон улсын ба гадаад донор орны 8 байгууллага хамрагдav.

Судалгааны агуулга, багтаамжийг: 1) Байгууллагын “паспортын” үзүүлэлтүүд; 2) Байгууллагын үйл ажиллагааных нь үндсэн чиглэл, зорилго, зорилтууд; 3) Хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төслүүдийн үндсэн үзүүлэлтүүд; 4) Байгууллагын чадавхи; 5) Байгууллагын санхүүжилт; 6) Байгууллагын ирээдүйн төлөв зэргээр хязгаарлав.

Анхдагч мэдээлэлд тоон ба утгын бүлэглэлт хийж, СОЦИО программаар боловсруулан, тайлан, санал-зөвлөмж бэлтгэлээ. Энэхүү судалгааны тайлан нь Удиртгал; Монгол улсын засгийн газраас 2000-2004 онд хэрэгжүүлэх нийгмийн бодлогын үндсэн зорилт, тэргүүлэх чиглэлүүд /товч тойм/; Монголын ТББ-ын өнөөгийн байдал; ТББ-уудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн төрөл, хэлбэр, санхүүжилт, ТББ-уудын үйл ажиллагаа ба Засгийн газрын бодлого хөтөлбөрийн уялдаа, ТББ-уудын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх давуу ба сул тал, үр дүн, ТББ ба донор байгууллагуудын хамтын ажиллагаа, судалгааны дүн, санал зөвлөмж гэсэн бүтэцтэй болно.

**Нэг. Монгол улсын Засгийн газраас 2000-2004 онд хэрэгжүүлэх  
нийгмийн бодлогын үндсэн зорилт, тэргүүлэх чиглэлүүд /товч тойм/**

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “боловсрол, соёлыг дээдлэн хөгжлийн гол тулгуур-хүнээ хөгжүүлэх”, “нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг боловсронгуй болгон нийгмийн хамгааллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар амьдралын түвшинг дээшлүүлэх” үндсэн зорилтоос гадна нийгмийн салбарын бодлогын гол зорилт, тэргүүлэх чиглэлүүдийг дор дурьдсанаар тодорхойлсон байна.

Нийгмийн салбарт баримтлах үндсэн зорилт нь хүний хөгжлийг хангах орчинг бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ. Энэхүү зорилт нь дараах тэргүүлэх чиглэлүүдээр хэрэгжих юм.

- Хүн амын боловсролын хэрэгцээг жигд хангах орчин бүрдүүлж, бүх нийтээр суурь боловсрол эзэмших, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, орчин үеийн мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэж, хүн амыг эрүүлжүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилтыг хэрэгжүүлнэ.
- Монгол улсын соёл, урлагийг дэлхийн соёлын нийтлэг ололт, үнэт зүйлс, дорнын соёлын өвөрмөц өнгө аястай уялдуулан эрчимтэй хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.
- Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадамжийг дээшлүүлэн хөгжлийн харьцаангуй шинэ давуу тал олж авах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэмтэд, судлаачдын бүтээлийн үнэлээмжийг өсгөх зорилтыг хэрэгжүүлнэ.
- Нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг оновчтой болгож ард иргэдийн амьжиргааны түвшингийн уналтыг зогсоон, нийгмийн доторхи орлогын ялгааг багасгаж, туйлын ядуурлыг арилгах зорилтыг хэрэгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн бус байгууллагыг дэмжих, хамтран ажиллах талаар “төрийн бус байгууллагыг дэмжиж, төрийн бодлого боловсруулах хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ялангуяа нийгмийн салбарт оролцоог нь өргөжүүлнэ” гэсэн заалт орсныг зориуд тэмдэглэж байна.

**Хоёр. Монголын төрийн бус байгууллагуудын  
өнөөгийн байдал**

**1. Эрх зүйн орчны бүрдэлт**

Монгол улсын Иргэний хууль, Аж ахуйн нэгжийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад төрийн бус байгууллага, түүний төрөл хэлбэр, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээг тодорхойлон заасан байна. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт: “Төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ” гэжээ. Тухайн зүйлийн 2,3-д зааснаас үзэхэд төрийн бус байгууллагыг дотор нь “нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага”, “гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага” гэж ангилдаг байна,

**Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагад** соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг оруулж заасан байна.

**Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага** гэж өөрийн гишүүддэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдэгээс бусад төрийн бус байгууллагыг оруулж заасан байна

Мөн иргэний хуулийн хоёр дахь хэсгийн 35-р зүйлд нэгдлийн талаар тусгагдсан байна. Энэ зүйлийн 1-д компани, нөхөрлөл, хоршоо нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болно. Энэ зүйлийн 2-д, нэгдлийг ашгийн төлөө, эсхүл ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр байгуулна. Энэ зүйлийн 3-д, олон нийтийн болон шашны байгууллага, сан нь гагцхүү ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр нэгдэл байгуулж болно гэж заасан байдаг. Мөн хуулийн 36-р зүйлийн 1,2,3-д олон нийтийн болон шашны байгууллага, сангийн талаар заасан байдаг.

Үүнд:

Оюуны, материаллаг болон материаллаг бус бусад ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдсэн иргэд, хуулийн этгээдийн нэгдлийг **олон нийтийн байгууллага** гэнэ.

Сүсэгтэн олны шашны зан үйл, хурал ном, боловролын хэрэгцээг хангах зорилго бүхий **байгууллагыг шашны байгууллага** гэнэ.

Нийгэм, соёл, боловсрол, буяны болон нийтэд тустай бусад зорилгоор сайн дурын хандив, тусlamж төвлөрүүлж, гагцхүү дүрэмдээ заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрх бүхий сайн дурын, гишүүнчлэлгүй байгууллагыг сан гэнэ.

Олон нийтийн болон шашны байгууллага, сан нь ашгийн төлөө бус байна гэж заасан байна.

Хүснэгт 1

## **2. Төрийн бус байгууллагын төрөл, хэлбэр**

Хэлбэр	Тодорхойлолт
<b>Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага</b>	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгуулгад соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллагыг оруулж заасан байна. (Төрийн бус байгуулгын тухай хууль, 4-р зүйл, 2)
<b>Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага</b>	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага гэж өөрийн гишүүддэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад төрийн бус байгууллагыг оруулж заасан байна. (Төрийн бус байгуулгын тухай хууль, 4-р зүйл, 3)
<b>Олон нийтийн байгууллага</b>	Оюуны, материаллаг болон материаллаг бус бусад ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдсэн иргэд, хуулийн этгээдийн нэгдлийг олон нийтийн байгууллага гэнэ. (Иргэний хууль 2 дахь хэсэг, 36-р зүйл, 1) Олон нийтийн байгууллага нь ашгийн төлөө бус байна. (Иргэний хууль 2 дахь хэсэг, 36-р зүйл, 4)
<b>Шашны байгууллага</b>	Сүсэгтэн олны шашны зан үйл, хурал ном, боловсролын хэрэгцээг хангах зорилго бүхий байгууллагыг шашны байгуулга гэнэ. (Иргэний хууль 2 дахь хэсэг, 36-р зүйл, 1) Шашны байгууллага нь ашгийн төлөө бус байна. (Иргэний хууль 2 дахь хэсэг, 36-р зүйл, 4)
<b>Сан</b>	Нийгэм соёл, боловсрол, буяны болон нийтэд тустай бусад зорилгоор сайн дурын хандив, тусlamж төлөврүүлж, гагцхүү дүрэмдээ заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрх бүхий сайн дурын, гишүүнчлэлгүй байгууллагыг сан гэнэ. (Иргэний хууль 2 дахь хэсэг, 36-р зүйл, 3) Сан нь ашгийн төлөө бус байна. (Иргэний хууль 2 дахь хэсэг, 36-р зүйл, 3)

## **3. ТББ-ын ангилал (үйл ажиллагааны чиглэлээр)**

ТББ-уудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн судалгаа

Одоогийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй 1615 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. ТББ-ын бүртгэлээс үзэхэд тэдгээрийг дараах байдлаар бүлэглэн ангилахаар байна.

Хүснэгт 2

	Үйл ажиллагааны чиглэл	Тоо	Эзлэх хувь
1	Биеийн тамир спорт	216	13.37
2	Соёл урлаг	172	10.65
3	Найрамдал, хамтын ажиллагаа	138	8.54
4	Эдийн засаг, бизнес	124	7.68
5	Эрүүл мэнд	81	5.02
6	Хүүхэд залуучууд	78	4.83
7	Хөдөө аж ахуй	77	4.77
8	Эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ	77	4.77
9	Мэргэжил	71	4.40
10	Эмэгтэйчүүд, гэр бүл	66	4.09
11	Боловсрол	64	3.96
12	Иргэдийн эрх ашгийн хамгаалал	55	3.41
13	Шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэл	55	3.41
14	Байгаль орчин	38	2.35
15	Нэрэмжит сангүүд	32	1.98
16	Өндөр настны үйлчилгээ	32	1.98
17	Энэрэнгүй үйлс, хүмүүнлэг тусlamж үзүүлэх	31	1.92
18	Тахир дутуу иргэдийн үйлчилгээ	29	1.80
19	Нийгмийн хөгжлийн дэмжлэг	28	1.73
20	Бүс нутгийн хөгжил	28	1.73
21	Хүний эрх хамгаалал	23	1.42
22	Мэдээлэл сурталчилгаа	22	1.36
23	Шашин	22	1.36
24	Эрдэм шинжилгээ судалгаа	17	1.05
25	Аялал жуулчлал	15	0.93
26	Сонирхлын бүлгүүд	13	0.80
27	Бусад	11	0.68

Эндээс үзэхэд ТББ-ууд биеийн тамир спорт (13.37%), соёл урлаг (10.65%), найрамдал, хамтын ажиллагааны (8.54%) чиглэлд илүү их үйл ажиллагаа явуулж байна.

#### **4. ТББ-ын орлогын эх үүсвэр, зарцуулалт**

Төрийн бус байгууллагын орлогын эх үүсвэр нь:

- Гишүүний хандив, татвар,
- Иргэд, аж ахуй нэгж, байгууллагын хандив,
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого,
- Зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө,
- Олон улсын байгуулага, гадаад орны төслийн санхүүжилт зэргээс бүрддэг ажээ.

ТББ нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргийг хуулиар хориглоно. ТББ-ын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг мөн хориглодог.

Төрийн бус байгууллага нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдэд эд хөрөнгө, хандив өгөх эрхгүй юм.


ТББ-ын эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байдаг. Иймээс төрийн бус байгууллагын шийдвэр гаргагчид нь тухайн төрийн бус байгууллагын доторх удирдлага байдаг.

Төрийн бус байгууллагын тухай Монгол улсын хууль батлагдаад дөнгөж 3 жил болж буй ч ТББ-ууд олноор үүсэн байгуулагдаж, нийгэмд зохих ёсоор байр сууриа олж, гүйцэтгэх үүрэг нь тодрон, ардчиллын ололт, иргэний нийгмийн төлөвшлийг илэрхийлж байна.

**Гурав. ТББ-уудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн төрөл хэлбэр, санхүүжилт**


Судалгаанд хамрагдсан ТББ-уд 1996-2000 онд нийгмийн салбарт нийт 302 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэний 57 нь 1996-1997 онд, 74 нь 1998 онд, 86 нь 1999 онд, 85 нь 2000 онд ноогдож байна.

График 1



Эндээс үзэхэд ТББ-уудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр нь жил бүр өсөж, түүнд хамрагдах байгууллага, хүмүүс, үйл ажиллагааны чиглэл, асуудлын цар хүрээ нь нэмэгдэж байгаа нь ТББ-уудын санхүүгийн болон ажил гүйцэтгэх чадавхи нэмэгдэж нийгэмд гүйцэтгэх үүрэг нь өсөж байгааг харуулж байгаа үзүүлэлт гэж хэлж болохоор байна. Түүнчлэн төсөл хэрэгжүүлж байгаа ТББ-ын тоо жилээс жилд нэмэгдсэн байна. Үүнийг доорхи графикаас харж болно.

График 2



Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ТББ-ын тоо өсөхийн хэрээр тэдгээр байгуулагын ажилтнуудын тоо, шинэ мэдээлэл, туршлага нэмэгдэж байгаа гэх үндэстэй бөгөөд цаашид донор орон байгуулагатай хамтран ажиллах боломж чадавхи нь тэр хэмжээгээр нэмэгдэж байгаа юм.

ТББ-уудын хэрэгжүүлсэн төслүүдийг үйл ажиллагааных нь чиглэлүүдээр ангилж үзэхэд нийгмийн асуудалд анхаарлаа хандуулах, тодорхой асуудлыг шийдвэрлэх /тухайлбал нийгмийн эмзэг хэсэгт туслалцаа үзүүлэх, ядуурал ажилгүйдлийг бууруулах/, нийгмийн асуудлын чиглэлээр нийгэмд болон гишүүддээ үйлчилгээ үзүүлэх /тухайлбал хүний эрх ардчилалыг дэмжих, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах/, сургалт явуулах шинэ мэдээлэл дамжуулах зэрэг үйл ажиллагаанууд давамгайлж байна.

Монголд байнгын үйл ажиллагаа явуулдаг донор 8 байгууллагын гаргасан судалгаагаар 1996-2000 онд тэдгээр байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр нийт 170 төсөл хэрэгжсэний бүтцийг авч үзвэл:

➤ Эрүүл мэндийн салбарт	32
➤ Боловсролын салбарт	45
➤ Нутгийн хөгжил /Community development/	35
➤ Ядуурлыг бууруулах	14
➤ Байгалийн гамшигтай тэмцэх	7
➤ Хүний эрх, улс төр, иргэн, нийгмийн асуудал	25
➤ Мэдээлэл харилцааны технологи	10
➤ Бусад	2

болж байна. Эндээс үзэхэд донор байгууллагуудын санхүүжүүлсэн төслүүдийн олонхи нь /77 төсөл/ боловсрол, эрүүл мэндийн салбарт хэрэгжжээ.

Харин 170 төслийн хэд нь ТББ-уудын оролцоотойгоор хэрэгжсэн нь тодорхойгүй байна.

Судалгаанд хамрагдсан 80 байгууллагын гаргасан тоо мэдээнээс харахад эдгээр байгууллагууд 1996-2000 онд 4426,7 сая төгрөгийн өртөг бүхий төсөл хэрэгжүүлснээс 298.7 сая төгрөгийн санхүүжилтийг дотоод эх үүсвэрээс, 4128.0 сая төгрөгийн санхүүжилтийг гадаадын эх үүсвэрээс тус тус хийсэн нь 6.7:93.3 хувийн харьцаатай байна. Эндээс үзэхэд манай орны ТББ-уудын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд гадаад эх үүсвэр зонхилдог бөгөөд энэ хандлага ойрын ирээдүйд хадгалагдах болов уу хэмээн судалгааны таамаг хийж байна.

### **Дөрөв. ТББ-ын үйл ажиллагаа ба Засгийн газрын бодлого,**

### **хөтөлбөрийн уялдаа**

Сүүлийн арван жилд Монгол улсын Засгийн газар ардчилсан сонгуулийн үр дүн болон бусад шалтгаанаар 7 удаа солигдсон ч түүний нийгмийн бодлого нь залгамж чанараа үндсэндээ хадгалсаар ирлээ. Засгийн газраас нийгмийн салбарт 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн, одоо ч үргэлжилсээр буй анхны хөтөлбөр бол Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр юм. Түүнээс гадна “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал”, “Хүүхэд, хөгжил, хамгаалал”, “Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр” гэх мэт үндэсний хэмжээний, “Боловсролын мастер төлөвлөгөө”, “Хүн амын эрүүл мэндийн боловсрол”, “Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах” зэрэг салбарын шинжтэй төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ирлээ. Мөн түүнчлэн Монгол улсын Засгийн газраас 1998 оныг “Залуучуудын жил”, 1999 оныг “Ахмадын жил”, 2000 оныг “Хүүхдийн эрхийн жил” болгосон билээ. Энэ бүхний үр дүнд олон түмний дунд социализмыг, түүний тэгшитгэл, бэлэнчлэлийг шууд санагалзан мөрөөдөх нь саарч, харин нийгмийн салбарын уналтыг зогсоох, урьдын хүрсэн түвшнээ хадгалах, шинэчлэн сэргээх гэсэн идэвх чармайлт нэмэгдэж, ТББ байгуулан ажиллах боллоо.

Судалгаанд хамрагдсан ТББ-уудын дийлэнхи олонхи нь буюу 76 байгууллага өөрийн үйл ажиллагааг Засгийн газрын бодлого, хөтөлбөртэй уялдаатай гэж үздэг байна. Эндээс нэгэн зүйлийн дүгнэлт хийхэд төр, засгийн нийгмийн бодлого, дэвшүүлсэн тодорхой зорилтууд нь энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг “төрүүлдэг” бололтой юм. ТББ-ын үйл ажиллагаа ба засгийн газрын бодлого, хөтөлбөр нь дараах чиглэлүүдээр илүү түлхүү уялдаж, давхцдаг гэсэн санааг судалгаанд хамрагдсан ТББ-ууд илэрхийлжээ. Үүнд:

- Хүүхэд залуучуудын хөгжил, боловсролын салбар;
- Нийгмийн эмзэг бүлгийг тэтгэн дэмжих;
- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлаас гаргах;
- Биеийн тамир, спорт, эрүүл мэндийн салбарын ажлыг дэмжих;
- Чөлөөт хэвлэл, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх;
- Бизнесийн хөгжлийг дэмжих, нийгмийн амьдралын бүх хүрээний менежментийг сайжруулах;
- Судалгаа хийх, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих;
- Иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах;
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах;
- Гадаад харилцааг хөгжүүлэх, улс хоорондын найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг болно.

Харин зарим нам, улс төрийн хүчний дэргэдэх олон нийтийн байгууллагууд нь төр, засгийн бодлого гэхээсээ илүү тухайн нам, хүчнийхээ үйл ажиллагааг илүүтэй дэмжиж, гишүүд дэмжигчдийнхээ улс төрийн идэвхийг өрнүүлэн нийгэмд тодорхой байр суурь эзлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Судалгааны дүнгээс ажиглагдсан нэг зүйлийг зориуд тэмдэглэж байна. ТББ-уудын үйл ажиллагаа нь олон чиглэлээр төр, засгийн бодлого, хөтөлбөртэй уялдаж давхцдаг ч гэсэн тодорхой төсөл хөтөлбөр дээр хамтран ажилласан, эсвэл Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлсэн гэхээр зүйл, түүнчлэн Засгийн газрын зарим тодорхой чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэсэн тохиолдол одоогоор алга байна. Эндээс ТББ-уудын үйл ажиллагаа нь Засгийн газрын бодлого, хөтөлбөртэй зорилт, чиглэлийн хувьд уялдаатай ч гэсэн амьдрал, бодит байдал дээрх хамтын ажиллагаа үгүйлэгдсэн хэвээр байгаа юм байна гэж дүгнэж болох юм.

**Тав. ТББ-уудын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх давуу ба сул тал, үр дүн**

**1. Зардал, үр дүн**

ТББ-ын хэрэгжүүлсэн төслүүдийн өртөг зардал, үр ашгийг тооцохын тулд хэрэгжүүлсэн төслүүдийг сургалт, судалгаа, мэдээлэл, сурталчилгаа явуулах, тодорхой чиглэлээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх гэсэн чиглэлүүдээр дахин ангилж авч үзлээ.

Үр дүнг тоон үзүүлэлтээр тооцож гаргахад судалгаанд хамрагдсан ТББ-ууд нь төслийн үр дүнг тооцон гаргахад шаардагдах санхүүгийн бүртгэл, тооцоог төдийлэн гаргаж чадахгүй байсан ба энэ ажилд илүү их цаг хугацаа, нарийвчилсан судалгаа шаардлагатай байсныг үгүйсгэх аргагүй юм.

Төслөөс үр шимийг нь хүртсэн хүмүүсийг шууд ба шууд бус үр шимийг хүртэгчид гэж хувааж үзэж болох байна.

Тухайлбал, ямар нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлийн төсөл, тодруулбал ажлын байр бий болгох, орлого нэмэгдүүлэх, халамжийн үйлчилгээ үзүүлэх, сургалтад оролцох зэрэг төслүүдэд хамрагдаж байгаа хүмүүсийг шууд, сургалтын төсөлд хамрагдсан хүмүүсийн цаашид бие даан явуулсан сургалтад хамрагдсан, сурталчилгаа мэдээллийг хүлээн авсан хүмүүсийг шууд бус үр шим хүртэгчид гэж хэлж болох юм.

1996-2000 онд ТББ-уудаас явуулсан 37 удаагийн сургалтад нийт 17685 хүн /давхардсан тоогоор/ хамрагдсан ба дунджаар нэг хүнд 9212 төгрөг ноогдож байна. Эндээс харьцангуй бага зардлаар олон хүнийг хамруулсан төсөл хэрэгжүүлсэн байна гэж хэлж болох боловч дундажлан тооцсон үзүүлэлт гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Төслөөс үр шимийг шууд хүртэгчдийн хувьд энэ тоо арай их, шууд бус үр шимийг хүртэгчдийн хувьд арай бага байх нь ойлгомжтой юм. Нөгөө талаар төслийн үргэлжлэх хугацаанаас хамаарч энэ тоо тухайн төсөл бүрд янз бүр байх юм.

Өнгөрсөн хугацаанд ТББ-уудаас явуулсан төслийн судалгаанд 170 гаруй засаг захиргааны нэгж, 1126 байгууллага, 110 өрх, 7490 гаруй хүн хамрагдаж өнөөгийн ханшаар тооцвол 135.543 ам. доллар зарцуулагджээ. Дээрхи тооцоонос харахад төсөлд хамрагдсан хүрээ, зарцуулсан хөрөнгийн хэмжээ харьцангуйгаар уялдаатай гэж хэлж болох боловч эцсийн үр дүнтэй нь харьцуулан үр дүн нь сайн, ашигтай байсан, үр дүн муу ашиггүй байсан гэж дүгнэх боломжгүй байлаа.

Нөгөө талаар ТББ-уудын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүн, үр ашгийг тооцон гаргах нэг үзүүлэлт нь иргэний нийгмийн салшгүй хэсэг болох ТББ-уудын өөрийнх нь ажил гүйцэтгэх болон бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн чадавхи

дээшилсэн явдал гэж хэлж болох ба үүний тод жишээ нь 20 саяас дээш зардалтай ТББ-уудын тоо 1.6 дахин нэмэгдсэнээр тайлбарлаж болох юм. Үр ашгийн талаар ярьж байхад зардал нь нэмэгдсэн байгуулагуудын тоо өссөн нь сайн гэж хэлэхийн учир нь үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ өргөжиж байгаагаар тайлбарлагдах юм.

1996-2000 онд ТББ-уудын хэрэгжүүлсэн нийгмийн эмзэг хэсгийнхнийг ажлын байраар хангах, орлого нэмэгдүүлэх төсөл, цэцэрлэгийн халамжийн бүлэг ажиллуулах, хоол хүнс, хувцас олгох, материаллаг баазыг бэхжүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах төсөл, хөтөлбөрүүдэд 73 байгууллага, 103 өрх, 10781 хүн хамрагджээ. Түүнчлэн дээрхи төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд эрүүл мэнд боловсролын байгууллагаар дамжуулан үйлчилгээ авсан хүмүүсийн тоо, төсөлд хамрагдсан өрхийн ам бүлийн тоо, хувь хүмүүсийн цаашид нийгэмд болон гэр бүлдээ үзүүлсэн шууд ба шууд бус үр ашгийг тооцоолон гаргавал чамгүй их тоо гарах ба үүнийг бодитоор тооцоолон гаргах цаг хугацаа, мэдээлэл хангалтгүй байсан боловч энэ нь дээрхи төслүүдийн үр дүн гэж хэлэхээс өөр аргагүй юм.

Дээрхи төслүүдийн нэг гол үр дүн бол нийгмийн тодорхой асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, хүмүүст мэдээлэл хүргэх үйлчилгээг сайжруулсан явдал гэж үзэж байна. Үүнийг дээрхи хугацаанд хууль сурталчлах, амьдрах ухааны сургалт сурталчилгаа хийх, сурталчилгааны материал тараах, үзэсгэлэн ажиллуулах, радио, телевизээр сурталчилгааны хичээл, сургалт зэрэг үйл ажиллагаанд 24 аймаг, 78 байгууллага, 20698 хүн хамрагдсанаас харж болох юм.

Нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай эмзэг бүлгийнхэнтэй ажиллаж, эрүүл мэнд, боловсролын салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж төрийн үйлчилгээний доголдож байгаа нэгээхэн хэсгийг нөхөж байгааг ТББ-уудын ажлын нэг өвөрмөц үр дүн гэж хэлж болох байна.

Түүнчлэн ажлын байр шинээр бий болгох, өрхийн болон хүмүүсийн орлого нэмэгдүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүд нь эдийн засгийн өсөлтийг хангахад өчүүхэн ч гэсэн хувь нэмрээ оруулж байгааг хэлэх хэрэгтэй байхаа.

Хүний эрх, ардчилалыг хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан хууль дүрэм, бодлого боловсруулан хэрэгжүүлэх, амьдралд хэрэгжүүлэхэд ТББ-уудын гүйцэтгэж байгаа үүрэг байнга өсч байгаа нь тэдний ажлын нэг гол амжилт гэж хэлэх үндэстэй.

ТББ-уудаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт нийт 38969 хүн хамрагдсан тооцоо гарч байгаа ба үүнийг нийт санхүүжилтэд харьцуулж үзэхэд нэг хүнд 66691,5 төгрөг ноогдож байна. Энэ нь явуулсан үйл ажиллагааны цар хүрээтэй

харьцуулахад нэг их биш тоо боловч нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ТББ-ууд идэвхтэй оролцвол тодорхой үр дүнд хүрч болохыг харуулж байгаа нэг жишээ гэж хэлж болох байна. Мэдээж хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн онцлогоос хамаарч энэ тоо өөр өөр байх нь ойлгомжтой юм.

Эцэст нь хэлэхэд ТББ-уудаас нийгэм болон гишүүддээ зориулан явуулж байгаа үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн үзүүлэлтийг тодорхой тоон үзүүлэлтээр гаргах нь хүндрэлтэй, төдийлөн оновчтой биш боловч үүнийг тооцох талаар ТББ-ууд анхаарах хэрэгтэй байна.

Негөө талаар төсөл хөтөлбөр өхлэх үеийн нөхцөл байдал ямар байв гэдгийг маш нарийн тооцож гаргаад төсөл дууссаны дараа ямар өөрчлөлт гарсантай харьцуулж тооцох талаар хангалтгүй анхаарч байсан гэж хэлж болохоор байна. Зөвхөн тухайн төсөл, хөтөлбөрт хамрагдсан байгууллага, хүний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ нь төслийн үр дүн, үр ашгийг тооцох хангалттай үзүүлэлт болж чадахгүй юм.

## **2. Зорилтот бүлэгтээ хүрдэг эсэх**

Судалгааны явцад анхаарал тавьсан нэгэн асуудал бол ТББ-уудаас хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь эцсийн дүндээ зорилтот бүлэгтээ хүрсэн, эсэхийг тогтооход чиглэгдлээ. Яагаад гэвэл тодорхой төсөл, хөтөлбөрийг тухайн байгууллага “өөрийн төлөө, эсхүл бусдын төлөө” хэрэгжүүлж байна уу? гэдэг нь нарийн бөгөөд зарчмын асуудал. Үүнийг судалгааны хэсгийнхэн хэр чинээндээ анхаарсан болно.

Давын өмнө тэмдэглэхэд судалгаанд хамрагдсан ТББ-уудыг зорилтот бүлгээр нь ангилахад дараах зориулалт, хаяглалт, байршилтай байна.

### ***Нийт хүн амын ба ТББ-ын бүрэлдэхүүний харьцуулалт***

Хүснэгт 3			
Нийт хүн амын бүрэлдэхүүн*	Хувий н жин	ТББ-ын ангилал	Хувий н жин
Хүүхэд	35.6	Хүүхэд	2.5
Залуучууд	30.3	Залуучууд	7.6
Өндөр настан	5.7	Өндөр настан	2.5
Эмэгтэйчүүд	50.4	Эмэгтэйчүүд	10.1
Тахир дутуучууд	0.3	Тахир дутуучууд Эмзэг бүлгийнхэн Нийгэмд болон мэргэжлийн бүлэгт үйлчилгээ үзүүлэх	1.3 5.1 60.8

	Гишүүддээ үйлчлэх	11.4
--	-------------------	------

\*-1999 оны нийт хүн амд тооцсоноор

Хүснэгтээс механик оноолтоор шууд дүгнэлт хийж болохгүй ч нийт хүн амын бүрэлдэхүүнийг ТББ-ынхтай харьцуулахад илүүдэхгүй. Харин ТББ-уудын хувьд зорилтот бүлгийн үүднээс хандахад манай ТББ-ууд нь дүрмээрээ бол нийгэмд үйлчлэх, нарийндаа бол тодорхой мэргэжлийн, мөн сонирхлын бүлгийнх гэж хэлж болохоор байна. Энэ ангилалд судалгаанд хамрагдсан ТББ-уудын 60.8 хувь нь багтаж байна. Дээр нь гишүүддээ үйлчилдэг байгууллагуудыг (11.4%) нэмж болно. ТББ-уудын үнэмлэхүй олонхи нь нэг бүлэгт багтаж буй нь сайн, бас сул талтай гэдэг нь ойлгомжтой.

ТББ-уудын хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг зорилтот бүлэгтэй нь харьцуулан үзэхэд эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэн, гишүүддээ гэсэн нь илүүтэй нийцэж буй нь судалгаанаас харагдav. Ихэнх ТББ-ууд дотоодын ба өөрийн эх үүсвэрээс бус, донор орон, байгууллагуудаас зонхилон санхүүжиж байгаа өнөөгийн нөхцөлд “зорилтот бүлэг” нь янз бүрээр хөдөлгөөнд ордгийг үгүйсгэх аргагүй ч ерөнхий дүнгээрээ төсөл, хөтөлбөр зорилтот бүлэгтээ очиж байгаа нь судалгаанаас харагдav. Энэ нь судалгааны нээлттэй асуултын хариултаар давхар нотлогдож байна.

“Танай байгууллагын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төслүүдийн хамгийн гол үр дүнг Та юу гэж үзэж байна вэ?” гэсэн нээлттэй асуултанд ТББ-уудын удирдах хүмүүсээс хариулт авахад респондентүүд нийт 136 хариу өгсөн нь 1 байгууллагад дунджаар 1.7 хариулт ноогдож байна гэсэн үг юм. Эдгээр хариултыг агуулгын ижил төстэй байдлаар нь бүлэглэж үзэхэд 17 чиглэл гарсан бөгөөд энэ нь 1996-2000 онд ТББ-уудын хэрэгжүүлсэн төслүүд нийгмийн амьдралын 17 чиглэлээр зохих үр өгөөжөө өгчээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

#### Хүснэгт 4

Төслийн гол үр дүн	Хариулт	
	Тоо	Хувь
Сургалт явуулж, оролцогчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлсэн	38	27.9
НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙН АЖ АМЬДРАЛД ТУС БОЛСОН	13	9.6
ХҮМҮҮСИЙГ ШИНИЙГ СЭДЭХ, УХААЛАГ АМЬДРАХ АРГА УХААНД СУРГАСАН	12	8.8
БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛСАН	8	5.9
НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХАД ТУСТАЙ БОЛСОН	8	5.9
ЗОРИЛТОТ БҮЛГИЙНХНИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАДАГ БОЛСОН	7	5.1
ӨӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МАТЕРИАЛЛАГ БААЗ САЙЖИРСАН	7	5.1

## ТББ-уудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн судалгаа

Оролцогчдын эрх зүйн мэдлэг, соёл дээшилсэн Үйл ажиллагааны хүрээ өргөжиж орон нутагт өөрийн салбар нэгжтэй болсон	7 6	5.1 4.4
Зорилтот бүлгийнхэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болсон	5	3.7
Хүүхэд залуучуудыг нийгэмшүүлэхэд түлхэц өгсөн Ном, сурх бичиг хэвлүүлсэн	5	3.7
Гадаад хамтын ажиллагаа өргөжсөн	5	3.7
Баг бүлгээр хамтран ажиллах арга барилд суралцсан	3	2.2
Салбар байгууллагын өөрчлөлт хөгжилд дэмжлэг үзүүлсэн	3	2.2
Сургууль завсардалт буурсан	2	1.5
ТББ-ын үй ажиллагааг төр засаг, олон нийтэд ойртуулахад ахиц гарсан	2	1.5
Дүн	136	100

Төсөл хэрэгжүүлэгч ТББ-уудын үнэлгээгээр нийгмийн салбарт хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй төслүүдийн гол үр дүн нь:

- Төсөлд хамрагдагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх (27.9%),
- Эмзэг бүлгийн амьжиргаанд тус болох (9.8%),
- Хүмүүсийг шинийг сэдэх, амьдрах арга ухаанд сургах явдал (8.8%), болдог ажээ.

Нийгмийн салбарт төсөл хэрэгжүүлснээр зорилтот бүлгийнхэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болж, баг, бүлгээр ажиллаж сурдгийн дээр хүүхэд, залуучууд нийгэмших процесс явагддаг байна. Энэ нь дам утгаараа мөн сургалтын үр дүн юм.

Дээр дурьдсанаас үзэхэд ТББ-уудын хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслүүд нь зорилтот бүлэгтээ шууд материалын болон мөнгөн тусламж, дэмжлэг үзүүлэхэд биш харин тэдний мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, амьдрах арга ухаанд сургахад гол төлөв чиглэдэг нь зөв өхлэл, ирээдүйтэй, хандлага хэмээн дүгнүүштэй.

### **3. ТББ-ын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхи**

Монголд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй 1615 ТББ 20 гаруй чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тухай өмнө дурьдсан билээ. Судалгаанд хамруулсан 80 ТББ, мөн донор 8 байгууллагаас авсан судалгааны дүнд тулгуурлан Монголын ТББ-уудын чадавхийг тодорхойлж байна.

Ингэхдээ тухайн байгууллагын хүний нөөц (орон тооны ажиллагчдын тоо), жилийн зардал, үндсэн хөрөнгийн хэмжээ (балансын өртгөөр), гишүүд, дэмжигчдийн тоо, орон нутагт салбартай эсэх зэрэг орцын тоон үзүүлэлтүүдийг үндэс болгосны дээр ТББ-ын үйл ажиллагааны тогтвортой байдал, нэр хүнд зэргийг харгалзсан болно.

Хүснэгт 5

**Судалгаанд хамрагдсан ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл**

	Үйл ажиллагааны чиглэл	Тоо	Хувь
1	Нийгмийн салбарын тодорхой асуудалд анхаарал хандуулах, шийдвэрлэх	20	25.0
2	Нийгмийн чиглэлээр гишүүддээ болон нийгэмд үйлчилгээ үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	18	22.5
3	Тодорхой салбарт мэргэжлийн үйл ажиллагаа явуулах	14	17.5
4	Сургалт явуулах, мэдээлэл түгээх	12	15.0
5	Судалгаа хийж, зөвлөгөө өгөх	10	12.5
6	Бизнесийн хөгжлийг дэмжих	4	5.0
7	Найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэх	2	2.5
	ДҮН	80	100

**a. Жилийн зардал**

ТББ-уудын бүртгэл, тооцооны систем цэгцрээгүй, энэ чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутмаг, тогтвр суурьшилтай ажилладаггүйгээс хамааран олонхи ТББ жилийн зардлаа нарийвлан тооцдоггүй байна. Нөгөөтэйгүүр ТББ-ууд судалгаанд зориулж зардал, санхүүжилтээ ил гаргах сонирхол багатай байдаг бололтой. Үүнийг 1996–1997 оны байдлаар 35, 1998 оноор 46, 1999 оноор 55 байгууллага тоо мэдээгээ гаргаж өгсөн явдал нотолж байна. Бидний олж авсан мэдээллээр бол ТББ-уудын жилийн зардал нь асар их ялгаатай, 1996–2000 оны хооронд дунджаар 1.0-ээс 315 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байжээ. Тухайлбал, орон нутгийн хөгжлийн сан зэрэг 13 байгууллага 1996, 1997 онуудад жилд 1.0–5.0 сая төгрөгийн зардал гаргасан байхад МУЗН, МХАYT, МYOХ, МХААХҮХ, ЛЭОС, Монголын хөл бөмбөгийн холбоо, “Улаанбаатар сан” 1998, 1999 онд 50.0–315.0 сая төгрөгийн зардал гаргажээ. Харин судалгаанд хамрагдаж, тоо мэдээгээ өгсөн олонхи байгууллагуудын хувьд (1999 оны байдлаар нийт байгууллагын 72.9%) жилийн дундаж зардал нь 5.0–19.0 сая төгрөг байгаа гэж тоймлож дүгнэхээр байна. Судалгааны дүнгээс ТББ-уудын санхүүгийн чадавхи

жилээс жилд дээшилж ирсэн гэж үзэх байна. Зөвхөн 1996-1999 онд 20.0 сая төгрөгөөс дээш жилийн зардалтай ТББ-ын тоо 1.6 дахин нэмэгдсэн баримт үүнийг нотолно.

Хүснэгт 6

**ТББ-уудын үйл ажиллагааны жилийн зардал**

(мэдээлэл өгсөн байгууллагын тоо, хувиар)

Жилийн зардал /сая төг/	1996–1997 он		1998 он		1999 он	
	тоо	хувь	тоо	Хувь	тоо	хувь
50-иас дээш	3	8.6	4	8.7	6	10.9
40 – 49	1	2.9	1	2.2	-	-
30 – 39	3	8.6	6	13.0	5	9.1
20 - 29	3	8.6	1	2.2	5	9.1
10 – 19	8	22.9	7	15.2	10	18.2
5 – 9	6	17.1	7	15.2	8	14.5
5 хүртэл	11	31.4	20	43.5	21	38.2
<b>Дүн</b>	<b>35</b>	<b>100</b>	<b>46</b>	<b>100</b>	<b>55</b>	<b>100</b>

Энд дурьдсан тоо баримт, нээлттэй асуултын дүнгээс үзэхэд ТББ-уудын санхүүгийн чадавхи жигд биш байдаг нь тодорхой байна. МУЗН, МYOХ, МХАҮТ зэрэг 6-хан байгууллагын жилийн үйл ажиллагааны зардал 50 сая төгрөгөөс дээш байхад судалгаанд хамрагдсан ТББ-уудын бараг тэн хагас нь жилд 5 сая хүртэл төгрөг зарцуулж үйл ажиллагаагаа явуулдаг ажээ.

**6. Хүний нөөц**

Хүний нөөц нь аливаа байгууллагын гол орц болж чадавхийг илэрхийлдэгийг харгалzan энэ судалгаанд ТББ-уудын төв болон салбар нэгжүүдэд ажиллагчдын тоог гаргаж дүгнэлт хийх зорилт тавьсан юм. Ажиллагчдын тооны талаар мэдээлэл гаргаж өгсөн ТББ-уудын дунджаар 1996-1999 онд нэг байгууллагад 11 ажилтан ноогдож байна. Энэ нь нэлээд их хүч мэт харагдах боловч байгууллагуудаар хуваарилагдсан байдал нь жигд биш байгаа юм.

Хүснэгт 7

**ТББ-уудын ангилал**

(Ажиллагчдын тоогоор)

Ажиллагчдын тоо /хүн/	1996–1997 он		1998 он		1999 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
50-иас дээш	1	2.1	1	1.7	2	2.9
40 – 49	1	2.1	1	3.4	2	2.9
30 – 39	3	6.3	1	1.7	2	2.9
20 – 29	-	-	-	-	-	-
10 – 19	10	20.8	14	24.1	16	23.5
5 – 9	10	20.8	10	17.2	13	19.1
5 хүртэл	23	47.9	30	51.7	33	48.5
<b>Дүн</b>	<b>48</b>	<b>100</b>	<b>58</b>	<b>100</b>	<b>68</b>	<b>100</b>

Хүснэгтээс үзэхэд судалгаанд хамрагдан тоо мэдээ өгсөн нийт ТББ-уудын 47.9-51.7 хүртэлх хувь 5 хүртэл ажиллагчтай, хоёрхон байгууллагаа 50-иас дээш ажиллагчтай нь харагдлаа. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүний тоо гол биш ч гэсэн ТББ-уудын олонхи нь энэ ажилд гаднаас хүн хүч татан оролцуулах шаардлагатай байдаг ажээ.

ТББ-уудын хүний нөөцийн үнэлгээнд боловсон хүчний мэдлэг, ур чадварыг харгалзах нь зүйн хэрэг. Судалгаанд хамрагдсан 80 ТББ-аар өөрсдийнх нь давуу ба сул талыг үнэлүүлэхэд давуу тал хэмээн 116 зүйл нэрэлсний 11.2 хувь нь, сул талаа 80 үзүүлэлтээр үнэлсний 11.3 хувь нь тус тус ажиллагчдын мэргэжил, ур чадвартай холбоотой байгаа нь сонирхол татахуйц тоо юм. Эндээс үзэхэд ажиллагчдын мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй гэсэн үнэлгээ үл ялих илүү байна.

## **в. Үндсэн хөрөнгө**

Судалгаанд хамрагдсан ТББ-уудаас 1996-1997 онд 29, 1998 онд 39, 1999 онд 45, 2000 онд 52 нь өөрийн гэсэн үндсэн хөрөнгөтэй гэж хариулжээ. 2000 оны байдлаар МУЗН, MXAYT, “Зориг” сан, MYOХ, Монголын хэвлэлийн хүрээлэн зэрэг 7 байгууллага 60.0 саяас дээш төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байхад олонхи нь буюу 55.8 хувь нь 5.0 сая хүртэл төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажээ. Хөрөнгийн бүтцийг авч үзвэл 40.0-өөс дээш сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгууллагууд өөрийн гэсэн байр, бусад үндсэн хөрнгөтэй байхад үлдэх хэсэг нь үйл ажиллагаа явуулах оффисийн тавилга, техник хэрэгслэлийн төдий хөрөнгөтэй ажээ. Ер нь улсын бүртгэлтэй ТББ-уудын дөнгөж 10 орчим хувь нь өөрийн байртай гэсэн мэдээлэл байна. Эндээс үзэхэд манай орны ТББ-уудын материаллаг бааз сул, дөнгөж

бүрдэх шатандаа яваа нь тодорхой. Үүнийг ТББ-ууд өөрийн давуу ба сул талаа үнэлсэн үнэлгээгээр ч нотолсон байна.

### **г. Гишүүнчлэл, зохион байгуулалт**

2000 оны байдлаар судалгаанд хамрагдсан байгууллагын 49 нь гишүүнчлэлтэй байгаагийн 42 нь хувь хүн гишүүнтэй, 6 нь байгууллага гишүүнтэй, 1 нь байгууллага-хувь хүн гэсэн холимог гишүүнчлэлтэй байна. Хувь хүн гишүүнтэй байгууллагуудыг гишүүдийнх нь тоогоор бүлэглэж үзэхэд 400-аас дээш тооны гишүүдтэй байгууллага зонхилж байгаа (55.1%) нь ТББ-уудын чадавхийн бас нэг үзүүлэлт юм. МУЗН хамгийн олон (245.0 мянга) гишүүнтэй байхад “Шинжээч”, “Зотол” зэрэг судалгааны төвүүд 3-7 гишүүнтэй байдаг ажээ. МХАҮТ, Үндэсний бүтээмж, хөгжлийн төв, хоршооллын байгууллагууд болон Их дээд сургуулиудын консорциум нь байгууллага гишүүнчлэлтэй, харин Монголын менежментийн холбоо байгууллага – хувь хүн гэсэн холимог гишүүнчлэлтэй байгаагаас МХАҮТ, Үндэсний бүтээмж, хөгжлийн төв, Монголын менежментийн холбоо, Их дээд сургуулиудын консорциумууд нь мэргэшсэн зөвлөхүүдийн хэд хэдэн багтай байгаа нь төсөл хэрэгжүүлэх өндөр чадавхитайг харуулж байна.

ТББ-уудын чадавхийн нэг үзүүлэлт болгож тухайн байгууллагын зохион байгуулалт, ялангуяа орон нутагт салбар нэгжтэй эсэхийг тодорхойлсон юм. Судалгаанд хамрагдсан 80 ТББ-аас 37 нь орон нутагт салбар нэгжтэй байгаагийн 19 нь бүх аймаг, хотод өөрийн төлөөлөлтэй ажээ. Эдгээр байгууллагуудыг дурьдвал: МУЗН, МСХ, Монголын ахмадын холбоо, МХЭАХН, МӨХ, Монголын анчдын нийгэмлэг, МҮҮХХ, МХААХХ, Ардчилсан социалист оюутны холбоо, Монголын нутгийн удирдлагын холбоо, Үндэсний бөхийн холбоо, Урлагийн ажилтны нийгэмлэгийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон эмэгтэйчүүдийн 6 байгууллага орж байна. Орон нутагт, ялангуяа бүх аймаг, хотод төлөөлөлтэй ТББ-ууд нь гишүүд, дэмжигчидтэйгээ тулж ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ зорилтот бүлэгтэйгээ дамжлагагүйгээр шууд харьцах зэрэг давуу талтай байгаа нь чадавхийн үзүүлэлт юм.

### **д. Бусад зүйл**

Монголд үйл ажилалагаа явуулж буй донор 8 байгууллагаар манай орны ТББ-уудын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхийн одоогийн байдал, ойрын ирээдүйг үнэлүүлэхдэд дараахь дүн гарч байна.

Хүснэгт 8

Байгууллагын нэр	Үнэлгээ	
	одоо	ирээдүй

ADRA Mongolia	Маш сайн	Сайжрана
ASIA Foundation	Дунд зэрэг	Сайжрана
Canada Fund	Маш сайн	-
Peace wind (Japan)	-	-
Save the Children Fund	Сайн	Сайжрана
MFOS	Маш сайн	Сайжрана
UNICEF	Сайн	Сайжрана
WORLD VISION int	Маш сайн	Сайжрана

Эндээс үзэхэд донор байгууллагууд манай орны ТББ-уудын төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлэх чадавхийг өндөрөөр үнэлж, цаашид итгэл үзүүлэх хандлагатай байгаа нь ажиглагдсаныг тэмдэглэж байна.

Судалгаанд хамрагдсан бүх байгууллага утастай, 65 нь факстай, 43 нь электрон шуудан ашигладаг байна.

#### **е. ТББ-уудын өөрийн үнэлгээ**

Судалгааны явцад ТББ-уудын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхитай уялдуулан “нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд ТББ-ын гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх арга замуудыг дурьдана уу?”, “Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд ТББ-ын давуу ба сул талыг дурьдана уу” гэсэн нээлттэй асуултуудаар санал авахад эхний асуултад нийт 136 хариулт ирснийг агуулгаар нь нэгтгэж 12 бүлэг болгон авч үзлээ.

Хүснэгт 9

	Тоо	Хувь
Санхүүгийн дэмжлэг авах	43	31.6
Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх	15	11
ТББ-ын тухай хуулийг боловсронгуй болгох	14	10.3
ТББ-ын ажлын арга барил, хамтын ажиллагааг сайжруулах	14	10.3
ТББ-ын өрсөлдөгчийг бий болгох	13	9.6
Боловсон хүчнийг чадваржуулах	9	6.6
ТББ иргэний нийгмийн шинжийг төлөвшүүлэх	9	6.6
ТББ-ын гадаад харилцааг өргөжүүлэх	7	5.1
Мэдээлэл, хангамжийг сайжруулах	4	2.9
Төрөөс ТББ- уудыг санхүүгийн хувьд дэмжих	3	2.2
Зорилтот бүлэгтэйгээ ажиллах	3	2.2
Судалгаа хийх	2	1.5

Дүн	136	100

Хариултын дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан ТББ-уудын бараг 1/3 нь гадаад, дотоодын санхүүгийн дэмжлэг авбал нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх тодорхой үүрэг гүйцэтгэх боломжтой гэжээ. Үүнийг бэлэнчлэх, гаднын тусlamж дэмжлэг авах сэтгэлгээний илрэл гэхээс илүү манай орны ТББ-уудын санхүүгийн дэмжлэг хүлээн авах, шингээх чадавхи бий болчихоод байхад донор орон, байгууллагуудын нэгэнт амалчихсан зээл, тусlamжийг гол төлөв манай талаас шалтгаалан бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй санхүүгийн хомсдолд орох болсонтой холбож үзвэл зохилтой. Ганцхан жишээ дурьдахад ЯБҮХ-ийн санхүүжилтийн тал хувийг л бид авч ашиглаад байгаа билээ.

Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд ТББ-ын үүргийг дээшлүүлэхэд Засгийн газар зарим чиг үүргээ гэрээний үндсэн дээр ТББ-аар гүйцэтгүүлэх явдал чухал ач холбогдолтой хэмээн 10 байгууллага тутмын нэг нь үзжээ. Энэ нь манай оронд явагдаж буй захиргааны шинэчлэлийн үзэл баримтлалтай нийцэж байгаагаараа ач холбогдолтой юм.

ТББ-уудын дунд өрсөлдөөн бий болгох явдал тэдгээрийн нийгмийн үүргийг дээшлүүлэхэд багагүй ач холбогдолтой гэж нэлээд байгууллага үзэж байна. Чухамхүү ТББ-уудын хооронд өрсөлдөөн сул байгаагаас нэг талаас Засгийн газрын, нөгөө талаас зарим нэг ТББ-уудын монополь шинж байна гэсэн зовнил зарим байгууллагуудад төрсөн нь харагдав.

ТББ нь иргэний нийгмийн шинжээ сайтар хадгалах (6.6%), боловсон хүчинээ чадваржуулан хүний нөөцөө нэмэгдүүлэх (6.6%) явдал ТББ-ын нийгмийн үүргийг нэмэгдүүлэх арга зам мөн гэснийг ч анхаарах хэрэгтэй.

ТББ-уудыг зорилтот бүлэгтэйгээ ажиллах, судалгаа хийх, хийлгэх, төрөөс шууд санхүүжилт авах мэтийн саналууд нэлээд байсан ч давтамж, хувийн жин нь харьцангуй доогуур тул дээрх арга замуудыг дурьдахад хангалттай хэмээн судалгааны хэсэг үзэв. Түүнчлэн шилжилтийн өнөөгийн нөхцөлд төслийн хөрөнгөөр төсвийн цоорхойг нөхөх, бизнес хийх, нэмэгдэл цалин, орлогын хэлбэрээр ашиглах хандлага байдгийг судалгаанд хамрагдагчид дурьдаад энэ нь нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд сөрөг нөлөөтэй хэмээн үзжээ.

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд ТББ-ын давуу болон сул талыг дурьдана уу” гэсэн нээлттэй асуултанд нийт 196 хариулт өгсөний 116 нь давуу талыг 80 нь сул

талыг илэрхийлсэн байна. Хариултын дүнгээс үзэхэд ТББ-ууд өөрийн гол давуу талаа

- Төр засгийн байгууллагаас хамааралгүй, хараат бус /21,6хувь/
- Иргэд, байгууллагын сайн дурын оролцоо өргөн /12,1 хувь/
- Зорилтот бүлэгтээ хүрч ажилладаг /13,8 хувь/ гэж үзсэн бол сул талаа ашгийн бус байдаг учраас санхүүгийн чадавхи сул /38.8 хувь/, ТББ-ын олон улсын сүлжээнд ороогүй /13,8 хувь/, материаллаг бааз хангалтгүй /11,3хувь/ хэмээн үнэлсэн нь бодит байдалд ихээхэн ойр үнэлэлт юм. Түүнчлэн мэдээлэл хангамж, төр засгийн ба ТББ-ын ажлын уялдаа холбоо, ил тод байдал зэрэгт ач холбогдол өгчээ.

#### **4. Дотоод гадаад нөөцийг дайчилсан байдал**

Судалгаанд хамрагдсан ТББ-ууд 4.128,0 сая төгрөгийн гадаад 298,7 сая төгрөгийн дотоод санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлжээ. Дотоод гадаад нөөцийн харьцаа 6,7:93,3 байна. Эндээс үзэхэд манай ТББ - ууд нь үндсэндээ гадаад эх үүсвэрийн хүчинд ажиллаж байна. Нэг талаас ТББ-ууд нь санхүүгийн гачаалд байна, нөгөө талаас нийгмийн салбарт донор орон, байгууллагуудаас амлсан зээл, тусlamжийг цаг алдалгүй авч бүрэн ашиглаж чадахгүй буйг дараахь хүснэгтээс харж болно.

Хүснэгт 10

Нийгмийн салбарт оруулсан зээл тусlamж, түүний ашиглалтыг  
хүснэгтээр харуулбал

/сая, ам.дол/

	Нийт амлалт	Хувь	Нийт ашиглалт	Хувь
Нийгмийн дэд бүтэц	308.6	14.9	241.8	78.4
Эрүүл мэнд	72.0	3.5	35.2	48.9
Хүний хүчин зүйлийн хөгжил	179.7	8.6	159.4	88.7
Нийгмийн хөгжил	56.9	2.7	47.2	83.0

Гадаадын зээл тусlamжийг салбарын бүтцээр нь авч үзвэл 1995-1998 онд 25 хувийг дэд бүтцийг хөгжүүлэхэд, 27 хувийг нийгмийн салбарыг дэмжихэд, 16 хувийг эдийн засгийн удирдлагыг сайжруулахад зарцуулжээ.

Иймд Монголын эдийн засгийн нийгмийн чиглэмжийг тодруулах зүүний Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх үүднээс нийгмийн салбарт

донор орон, байгууллагуудаас хэрэгжүүлэх зээл тусlamж, төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэхийг санал болгож байна.

ТББ-удын чадавхи нь гадаад дотоод санхүүгийн нөөц дайчлалтаар зогсохгүй эцсийн дүндээ Монгол хүний нэн ялангуяа залуучууд, чамгүй боловсролтой эмэгтэйчүүдийн нөөц ашиглалт, дайчлалтаар илэрхийлэгдэнэ.

Иймэрхүү хандлагыг харгалзан үзвэл өнөөгийн Монголчуудын мэдлэг боловсрол, оюун ухаан, авьяас билэг төрийн болоод ТББ-ын хүрээнд тэр болгон дайчлагдахгүй байна. Өнөөдрийн байдлаар манай улсын олон мянган залуучууд гадаад орнуудад цагаачилж, хар бор ажил хийж, хөдөлмөрийн зах зээлийн “шавхруу долоож” амь зууж буй нь нууц биш юм.

Иргэний нийгмийг төлөвшүүлэх, нийгмийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд ТББ-удын нэгэнт бий болсон бүтэц, чадавхийг дайчлах нь төрийн үйлчилгээг аль болох бага зардлаар шаардлагатай хүнд нь хүргэх нэг боломж боловч үүнийг ашиглах талаар хангалтгүй анхаарч байгаа нь судалгаанаас харагдаж байна. ТББ-уд төв болон орон нутгийн төсөвтэй харьцаж ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа нь үүний баталгаа юм.

Нөгөө талаар ТББ-уд нь хуулийн дагуу ямар нэгэн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах боломжгүй нь зөвхөн донор, орон байгууллагын тусlamж, төрийн дэмжлэгийг санхүүгийн хувьд авахаас өөр аргагүй болгоход хүргэдэг тал байгааг анхаарахгүй байж болохгүй юм.

**Зургаа. ТББ ба донор байгууллагуудын хамтын ажиллагаа**

ТББ-уудын донар орон, байгууллагуудтай нийгмийн салбарт хамтран ажиллах хэрэгцээг нээлттэй асуултаар тандан судлахад 94 санал гаргасныг нэгтгэж үзэхэд судалгаанд хамрагдсан байгууллагуудын санал болгож буй хамтын ажиллагааны хэрэгцээний бараг тэн хагас нь /47.9 хувь/ хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн ерөнхий санал, 22.4 хувь нь ТББ-уудын өөрийнх нь чадавхийг дээшлүүлэх, санхүүгийн болон хяналтын тогтолцоо бий болгоход дэмжлэг авах зэрэг байгууллагын дотоод хэрэгцээ байгаа нь сонирхол татаж байна. Эндээс нэгд, манай ТББ-ууд нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулах чиглэл, зорилтоо хараахан бүрэн тодорхойлж чадаагүй байна. Хоёрт, ТББ-уудын өөрийн чадавхи үнэхээр сул учраас зөвхөн өөрөө оршин тогтох түвшинд ажилладаг юм байна гэсэн дүгнэлтүүдийг хийж болох байна. Нөгөөтэйгүүр тавьсан асуултын утга учрыг гүйцэд ойлгоогүй байж болохыг үгүйсгэхгүй.

Мөн энэ асуудлаар донар байгууллагуудын саналыг авахад дараахь байдалтай байна.

Донар байгууллагууд нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын үйл ажиллагаанд эерэг дүгнэлт өгөхийн сацуу сүүлийн жилүүдэд тэдний хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд өргөн цар хүрээтэй болж зорилтот бүлэгтээ хүрч ажиллаж байгааг тэмдэглэжээ. Түүнчилэн ТББ-ын чадавхи, үйл ажиллагааг тогтовортой болон “цаг үед” (ad hoc) нь дэмжиснээр иргэний нийгмийг төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, хүн төвтэй нийгмийн хөгжлийг дэмжих өргөн бололцоотой гэж үздэг байна.

Үүний тулд нийгмийн хөгжлийн бодлого, стратеги боловсруулах, тодорхой хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл болох хувийн хэвшлийнхэн хандивлагч байгууллагуудын саналыг харгалзан үзэж,

дэвшлийн төлөө түншлэлийг зохистой дэмжих нь зүйтэй гэсэн санаа гарсныг зориуд тэмдэглэж байна.

Монголын ТББ-ууд болон хандивлагч байгуулагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, төлөвшүүлснээр цаашид нийгмийн хүрээнд доорхи салбар, дэд салбаруудад хамртран ажиллах боломжтой хэмээн судалгаанд хамрагдсан донор байгууллагууд үзэж байна. Үүнд:

1. Боловсрол

- a. Сургуулийн өмнөх насны боловсрол
- b. Бага дунд сургууль
- c. Их, дээд, мэргэжлийн сургууль
- d. Албан бус болон зайны сургалт

2. Эрүүл мэнд

- a. Урьдчилан сэргийлэх
- b. Эмчилгээ

3. Мэдээлэл

- a. Хүртээмж, чанар
- b. МХТехнологи
- c. Иргэдийн мэдээлэл хүртэх боломж, орон зай
- d. Хэвлэл, мэдээлэл

4. ТББ-ыг дэмжих

- a. Хүний эрх
- b. Ядуурлыг бууруулах
- c. Иргэний боловсрол
- d. Гэр бүл төлөвлөлтийн асуудал
- e. Хүрээлэн буй байгаль орчин
- f. Хотол /нутгийн хөгжил/ гэх мэт.

Нийгмийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг зохицуулан, шинээр урган гарч буй асуудлуудыг дэвшүүлэн хэлэлцүүлэх механизм бүрдүүлэх нь зүйтэй гэсэн санал ч гарч байв.

Өнөөгийн хурдацтай хөгжиж буй мэдээллийн эрин зуунд Монголын харьцангуй давуу тал мэдээлэл, холбооны технологийн хөгжил байж болох юм.

Нийгмийн салбарын тулгамдсан асуудлаар Монгол-Англи хэл дээр веб хуудсууд нээж, байрлуулснаар мэдээллийг солилцох өргөн бололцоо нээгдэж, түншлэлийн шинэ хэлбэр төлөвшин буй хэмээн донор байгууллагууд үзэж байна.

## **Долоо. Судалгааны дүн, санал зөвлөмж**

Манай судалгааны хэсэг Монгол орны ТББ-ын талаар богино хугацаанд, нэлээд олон асуудал хөндсөн, сонирхолтой судалгаа хийсэндээ тулгуурлан, дараах үнэлэлт, дүгнэлт, санал, зөвлөмжийг захиалагч байгууллагын анхааралд толилуулж байна.

### **1. Үнэлэлт, дүгнэлт**

- Монгол оронд ардчилал хөгжиж, иргэний нийгэм төлөвшиж буйг өнөөгийн ТББ-уудын үүсэл, төвхнөл харуулж байна. Судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн ТББ-үүд нь “өсөлтийн” гэгдэх шатандаа “алдаа онооны” замаар урагшилж байна. Тийм ч учраас зорилго үйл ажиллагааны чиглэл нь тодорхойгүй байх, бүртгэл тооцоо сул, боловсон хүчний хангамж, тогтвортсуурьшил хангалтгүй байх зэрэг өсөлтийн бэрхшээлүүд түгээмэл ажиглагдаж байна.
- Монгол оронд харьцангуй богино хугацаанд, “Төрийн бус байгууллагын тухай хууль” батлагдангуут “дэлбэрэлтийн байдлаар” ТББ-үүд байгуулагдан, үйл ажиллагаагаа өрнүүлж байна. Ийм “дэлбэрэлт” үүсэхэд донор орон, байгууллагуудын тусlamж, дэмжлэгээр хэрэгжүүлж буй ЯБҮХ, Чөлөөт хэвлэл, зэрэг хөтөлбөр, “Нэг ертөнц”, “Зайны сургалт”, “Нэхөн үржихүй эрүүл мэнд” зэрэг төслүүд нь “өдөөгч” нь болжээ.
- Монгол улсад шинэ тулгар ТББ-үүд үүсч, хөл дээрээ тэнцэхэд нь НҮБ-ын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газар, түүний хөгжлийн хөтөлбөр, Хүн амын Сан, ДАНИДА, ЖАЙКА, Монголын Нээлттэй Нийгмийн Сан, AusAID зэрэг байгууллагууд онцгой үүрэг гүйцэтгэсэн нь судалгаанаас харагдлаа.

- Манай ТББ-ууд нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, тусlamж, дэмжлэг авч, шингээх чадвар сууж байгаа ч одоогийн шатанд тэд хэрэгжүүлэгч бус, харин идэвхжүүлэгч (сурталчилгаа, мэдээлэл, сургалт, судалгаа)-ийн үүрэг голлон гүйцэтгэдэг байна.
- Манай ТББ-ууд нь саявтархан үүсэн байгууллагдсан, туршлага суугаагүй, бэл бэнчин тааруу чадавхиар сул тул донор орон, байгууллагуудаас “хүлэмжийн нөхцөл” шаардаж буйг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

## **2. Санал-Зөвлөмж**

ТББ-уудыг нийгмийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн идэвхижүүлэгчийнхээс хэрэгжүүлэгчийн байр суурь, үүрэгтэй болгохын тулд нэгд, үйл ажиллагааных нь чиглэл, хүрээг өргөжүүлж идэвхжүүлэх, хоёрт, зохих тусlamж, дэмжлэгийг донор орон байгууллагуудаас хүсэх хэрэгцээ шаардлага бодитой оршиж байна.

1. Манай улсад, ялангуяа нийгмийн салбарт Монгол улсын Засгийн Газрын Нийгмийн Бодлогыг дэмжиж хэрэгжүүлэхүйц ТББ-ууд тооны хувьд бий болсоныг харгалзан, “Засаглалын бүрэн эрх”-д хамаарахаас бусад чиг үүргийг ТББ-уудад зоримог бөгөөд дэс дараатай шилжүүлэх,
2. Засгийн Газрын төсөл, захиалгын тендерийг улам ил тод, олон орц, гарцтай болгох,
3. Засгийн Газрын хөтөлбөр, төсөл, захиалгад оролцох, гүйцэтгэх, хэрэгжүүлэх шатанд өрсөлдөөнийг бий болгох, тэгэхдээ ТББ-ууд шудрага, ижил нөхцөлд өрсөлдөх эрх зүйн орчныг бүрдүүлэх,
4. Төсөл хэрэгжүүлж буй ТББ-уудыг эрсдэлээс хамгаалах даатгалын санг Засгийн газар бүрдүүлэх,
5. Төсөл хөтөлбөрийг гол төлөв санхүүгийн эх үүсвэрээр нь бус үр дүн, өгөөжөөр нь үнэлдэг, дүгнэдэг шалгуурт аажмаар шилжих,
6. ТББ-уудад “хүлэмжийн нөхцөл” бүрдүүлэх чиглэлээр бус, харин тэдгээрийн чадавхийг дайчлах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийх, дэмжлэг, тусlamж үзүүлэх,
7. ТББ-уудын талаархи мэдээллийн санг тэдгээрт бус нийгэмд хүртээх чиглэлээр бүрдүүлэх
8. ТББ-уудын хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа олон нийт, ТББ-уудын өөрсдийнх нь саналыг авч тусгах, Засгийн газрын нийгмийн салбарын зорилт, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхүйц ТББ-уудыг үүсгэн байгуулах тэтгэн, дэмжихийн хамт ТББ-уудад “мөнгө угаах”, татвараас зайлсхийх,

- дүрмийн бус үйл ажиллагаа явуулах үүд хаалгыг хаах асуудлыг хуульд нэмэлт, өөрчлөлт, оруулах үед анхаарах,
9. Засгийн газрын одоогийн хуулийн хүрээнд янз бүрээр эрэмблэгдэж, яамдад өөр өөрөөр харьялагдаж буй байгууллага, газруудад хүртэл ТББ-уудын үйл ажиллагааг нээлттэй болгох, Тухайлбал: Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэхээр гэрээлэх хэлбэрт шилжүүлж нийгмийн үйлчилгээний салбарын улсын байгууллагуудын монополь шинжийг задлах зардлаа тооцож, чанараа сайжруулах замаар үйлчилгээний захиалга олж авахын төлөө өрсөлдөөнийг хөгжүүлэх
10. Томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ-уудын нөөц, чадавхийг төвлөрүүлэхийн хамт тэдгээрийн дундаас толгойлогч-зохицуулагч байгууллагыг чадавхийг гол үзүүлэлт болгон шалгаруулж ажиллуулах
11. ТББ-уудын талаар багц үзүүлэлтийг үндэсний статистикийн эмхтгэлд суулгаж, нийтийн хүртээл болгох зэрэг болно.

***Монголын төрийн бус байгууллагуудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төслүүдийн матриц***

Хандивлагч орон, байгууллагуудын санхүүжилтыг гол шалгуур болгон, судалгаанд хамрагдсан төрийн бус 80 байгууллагын 1996-2000 онд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслүүдийн матрицыг 1996-1997, 1998, 1999, 2000 оноор гаргалаа. Матрицыг байгууллагын нэр, үйл ажиллагааны үндсэн чиглэл /дүрмэндээ зааснаар/, зорилтот бүлэг, хэрэгжүүлсэн төслийн нэр, товч тодорхойлолт, хамрагдсан байгууллага, хүний тоо, төслийн дундаж өртөг, үргэлжилсэн хугацаа зэрэг үзүүлэлтээр байгуулав.

Матрицаас үзэхэд дээрх 80 байгууллагаас 1996-1997 онд 13, 1998 онд 17, 1999 онд 21, 2000 онд 20 ТББайгууллага нийгмийн салбарт донор орон, байгууллагуудын санхүүжилттэй 302 төсөл хэрэгжүүлсний нийт өртөг нь өнөөдрийн ханшаар 4.426,7 сая төгрөг болж байна.

Төсөл хэрэгжүүлэгч ТББ-уудаас Монголын хэвлэлийн хүрээлэн, Их дээд сургуулиудын консорциум, Удирдлага, эдийн засгийн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын консорциум, ЛЭОС, Монголын хөгжлийн төв зэрэг байгууллагууд тогтвортой үйл ажиллагаа явуулж, харьцангуй том төсөл хэрэгжүүлж иржээ. Харин ихэнх ТББ-ууд донор орон, байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрт хамрагдаж амжаагүй байна. Гэсэн ч төслийн хэрэгжилт томоохон хотуудаар зогсохгүй хөдөө орон нутгийг хамарсан нь цөөнгүй.

Төслийн санхүүжилтэд UNDP, TACIS, DANIDA, JAICA, USIAD, MFOS, DAD, AusAID, Английн ХИС сан зэрэг байгууллагын санхүүжилт зонхилж ирсэн нь матрицаас харагдаж байна. Тэрчлэн хэрэгжүүлсэн төслүүд нь зорилтот бүлгийг сургалтад хамруулах, тэдэнд материалаг тусламж үзүүлэх, мэдээллийн сүлжээ бий болгох, нийгмийн чиглэлээр судалгаа хийхэд голлон зориулагджээ.

Жич: Судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох файлаас үзэж болно.